

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймгийн Архивын тасгийн цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөний дагуу 4 хөмрөгийн 126 хадгаламжийн нэгжийн 8427 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

Мөн иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу 263 иргэн, 20 байгууллагад архивын баримтын лавлагаа мэдээллийн үйлчилгээг хүргэж ажиллалаа. Үүнд захирамжлалын баримт бичгийн хуулбар 507, мал тооллогын баримтын лавлагаа 123, цалингийн лавлагаа 26, хүн амын бүртгэлийн лавлагааны 27 үйлчилгээг тус тус үзүүлсэн.

Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд:

Хүнсний чанар стандарт, эрүүл ахуйн хяналтаар:

Ардын хувьсгалын 102 жил, Хөвсгөл аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023.02.14-ний өдрийн 08-00/01 дугаартай “Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжаар Мөрөн сумын Далай ээж, Цагаан-Уул, Шинэ Мөрөн хүнсний зах болон хүнс үйлдвэрлэлийн 3, худалдаа эрхлэгч 165, хоолны газар 16, баяр наадмын үеэр үйл ажиллагаа явуулж байсан 64 хуушуурын гэр, шорлогны цэг 3, нийт 252 объект хамрагдлаа.

Хоол, хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн технологи ажиллагааны горим, ашиглаж буй түүхий эд, боловсруулсан болон худалдан борлуулж буй хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, гарал үүсэл, баталгаажилтын баримт бичиг, хаяг шошгын мэдээлэлд хяналт тавьж, ундны усны эрүүл ахуйн чанар, ус хадгалах савны зориулалт, угаалга цэвэрлэгээ, хуванцар болон нэг удаагийн аяга таваг, нийлэг уутны баталгаажилт, ажилчдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байдал, дотоод хяналтыг хэрхэн зохион байгуулдаг зэрэг асуудлыг шалгалаа.

Шалгалтын явцад 204 зөрчил илрүүлж, 168 буюу 82.3% хувийг нь арилгуулж, 65 заалт бүхий 2 албан шаардлага, 47 заалт бүхий 2 төрлийн зөвлөмжийг гарган, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Эрдэнэбулган, Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Түнэл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Хатгал, Алаг-Эрдэнэ сумдын хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 92 аж ахуй нэгж, иргэнд баяр наадмыг угтан дотоод хяналт, зохистой дадлыг хэрэгжүүлэх анхаарах талаар сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Эрүүл мэндийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 10-00/31 дугаартай “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай”, 10-00/32 дугаартай “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” болон Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/13 дугаартай “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжуудаар Уран дөш зуслангийн үйл ажиллагаанд аймгийн Эрүүл мэндийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар хамтарсан хяналт шалгалт хийж, холбогдох хяналтын хуудсуудаар үнэлгээ, дүгнэлт өгч улсын ахлах байцаагчийн хамтарсан 42 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн ажилласан.

Байгаль орчны хяналтын чиглэлээр:

Байгаль орчин аялал, жуулчлалын яамны салбарын хяналтын газрын 01/05 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Ан агнах, барих, худалдах, худалдан авах, тээвэрлэх байдалд Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, норм, стандартын хэрэгжилтийг Бүрэнтогтох, Цагаан-Уул, сумдад хууль бусаар тарвага агнахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтыг 2023 оны 07 дугаар сарын 13-16-ний өдрүүдэд хийв.

Мөрөн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хөрөө рам, ойн мэргэжлийн байгууллагад шалгалт хийсэн. Аймгийн Цагдаагийн байгууллага, Тагнуулын газартай хамтран Тосонцэнгэл сумын орчимд ургадаг каннибас гэгдэх ургамлыг устгах ажилд оролцов.

Аймгийн Онцгой байдлын газрын хүсэлтийн дагуу Ханх сумын төвд Хөвсгөл нуураас татан гаргасан тракторын шатахууны сав, хөдөлгүүр, туслах моторын шингэнээс болон Хөвсгөл нуурын уснаас дээж авч шинжилгээнд хамруулан дүгнэлт гаргаж, хүргүүллээ.

Могойн гол ХХК-д хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд зөрчлийн хэрэг нээн шалгаж, хялбаршуулсан журмаар 500,000 (таван зуун мянган) төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцов.

Хөвсгөлд зочлох жилийн хүрээнд хийгдэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгээс “Нэмэн ХХК-ийн ШТС-ийн гадна талбай нь эмх замбараагүй байгаа тул арга хэмжээ авч өгнө үү” гэсэн хүсэлтийг Аймгийн Засаг даргын Тамгын газарт харьяаллын дагуу шилжүүлснээр тус ШТС-ын үйл ажиллагаа нь стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд шалгалт хийж, зөрчлийг арилгуулсан тухай хариу ирүүлсэн байна.

Мөрөн ХТҮТөв ХХК-тай холбоотой гомдлыг хянан шалгаж, Зөрчлийн тухай хуулийн 7.10.1 дэх заалтын дагуу 450000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцов.

Аймгийн Засаг дарга нарт хяналт шалгалт хийх зардлын асуудлыг шийдвэрлэх албан бичиг ирүүлсний дагуу хяналт шалгалтад шаардагдах зардал төсвийн нэгтгэлийг гаргаж, аймгийн Засаг даргад хүргүүлсэн. Бүрэнтогтох сумын байгаль орчны хяналтын

улсын байцаагчийн эрх авах ажилтан томилогдсон материалыг Байгаль орчин аялал жуулчлалын яамны салбарын хяналтын газарт хүргүүлэв.

Онцгой байдлын чиглэлээр:

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгаа:

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Эрчим хүчний сайд нарын баталсан удирдамжийн дагуу Эрчим хүчний барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг “Хөвсгөл эрчим хүч” ХХК-ий 6кВ-н хувиарлах Мөрөн дэд станцад Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч-1, Гал түймрийн улсын хяналтын байцаагч-2 бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулан ажиллав.

Аймгийн Засаг даргын 2023 оны 03-р сарын 23-ний өдрийн А/104 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг Алаг-Эрдэнэ сумын Манжилын голын гүүрний их засвар, арчлалт шинэчлэлийн ажлыг хүлээн авахаар 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдөр Улсын комисст орж ажиллав. Мөн Цэцэрлэг сумын ЕБС-ийн 150 хүүхдийн дотуур байр, Цагаан-Уул сумын Спорт заал, Баянзүрх сумын соёлын төв Бүрэнтогтох сумын Бүрэнхаан багийн Эрүүл мэндийн төвийн сантехникийн засвар ажлыг хүлээн авахаар 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдөр Улсын комисст орж ажиллав.

Үндэсний их баяр наадмын өдрүүдийг тохиолдуулан иргэд, хүүхдүүдийг Дэлгэрмөрөн голын эрэг дагуу усанд орж тоглох, асран халамжлах хүнгүй бага насны хүүхдийг гол, усны болзошгүй осолд өртөх, гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд, амь насаа алдаж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор болзошгүй усны ослоос урьдчилан сэргийлэх удирдамж гарган Онцгой байдлын газар, 2023 оны 07-р сарын 09-ний өдрөөс 2023 оны 07-р сарын 12-ны өдөр хүртэл 10 цагаас оройн 20 цагийн хооронд Дэлгэрмөрөн голоор Нисэх 1-р багийн нутаг Цагаан-Эрэгээс Урандөш 8-р багийн нутаг Бойны хашаа хүртэлх газар автомашинтай, завьт болон явган эргүүл хийж 5000 гаруй иргэнд санамж анхааруулга 450 ширхэг гарын авлага тараах материал тарааж ажилласан.

Мөрөн сум тойрсон үерийн далан болон үерийн ус ордог баг, гудамжны айл өрхүүд, хатуу хучилттай автозамын доогуурх ус зайлуулах хоолойны ус нэвтрүүлэх байдалд ОБГазрын ГХТББХАМ хошууч С.Ганболд, ГТУА 27-р ангийн салааны захирагч ахлах дэслэгч Д.Ганбаатар, Мөрөн сумын архитектур, нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн Ш.Баасанпүрэв, Мөрөн сум байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхтөр, Хот тохижилт, зам хариуцсан мэргэжилтэн Болор-Эрдэнэ, ГХБХБГ-ын ахлах мэргэжилтэн Э.Аззаяа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2023 оны 07 дугаар сарын 23-аас 07 дугаар сарын 24-ний хооронд үзлэг хийж ажиллалаа. Үзлэгээр Мөрөн сумын баг хороодын хатуу хучилттай автозамын доогуур байрлуулсан ус зайлуулах хоолой болон засмал замын арын гудамжны айл өрхүүдийн үерийн уснаас хамгаалагдсан байдалд эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийв.

Үерийн гамшгийн нөхцөл байдал хүндэрсэн үед ажиллах ГХА, МА, хуулийн этгээдийн техник, хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж холбогдох тоон мэдээ судалгааг ОБЕГ, Хойд бүсийн төвд тухай бүр хүргүүлж ажиллав. Хүч хэрэгслийн судалгааг 2023 оны сүүлийн хагас жилийн байдлаар гаргаж мэдээ судалгаанд хавсаргав.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023.07.04-ний өдрийн 1/1502 дугаар захирамжаар үүргийн дагуу бэлтгэл бэлэн байдлаа хангаж зуны улирлын амралт аялал зугаалга эхэлсэнтэй холбогдуулан Хатгал тосгоны Нефьт баазаас Эгийн голын гүүр болон отголох цэгүүдээр бэлтгэл ээлжийн алба хаагчид үер усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Бэлтгэл бэлэн байдал, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2023 оны 7 сард объектын гал түймэр -4 суманд нийт-4 удаа гарч өвөл, зуны сууц-1, машин техник-1, монгол гэр-2, гал түймэрт өртөж 56,300,000 / тавин зургаан сая гурван зуун мянган төгрөг /-ний эд хөрөнгө аварсан, гал түймрийн улмаас 63,025,000 /жаран гурван сая хорин таван мянган төгрөг/-ний хохирол учирсан байна. Гал түймрийн дуудлагад давхардсан тоогоор 5 техник хэрэгсэлтэйгээр 27 алба хаагч 30 хүртэлх минут ажиллаж 4 тонн унтраах бодис зарцуулж ажилласан байна.

Тайлангийн хугацаанд Хөвсгөл аймгийн Мөрөн, Баянзүрх, Бүрэнтогтох сумын нутаг дэвсгэрт тохиолдсон 5 дуудлагаар 7 офицер, 25 ахлагч гарч ажиллаж, 16 хоног үүрэг гүйцэтгэж 1 иргэний амь насыг аварч, 3 буцалтгүй нэрвэгдэгчийг эрэн хайн олж, 2 сая төгрөгний эд хөрөнгийг авран хамгаалж ажилласан.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Харгана багийн Дунд харгана, Мухар харгана, Түлэт, Даваат, Элстий гэдэг газруудад /аймгийн төвөөс зүүн урьд зүгт 193км-ээс 212км зайд, сумын төвөөс зүүн урьд зүгт 17км/-т 2023.07.08-ны өдрийн 19:00 цагаас 21:00 цаг хүртэл, 23:00 цагаас 03:00 цагт хүртэл хүчтэй аадар бороо орсны улмаас 20 орчим айл өрхийн, 100 орчим бод, 600 орчим бог мал үерт урссан тухай мэдээллийг 2023.07.09-ний өдрийн 10:55 цагт хүлээн авсан.

Гэмт хэрэг, зөрчлийн чиглэлээр:

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газар, Цагдаагийн газрын зорилт, бодлого чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай ажлаа уялдуулан хамтран ажиллалаа.

Гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр 16 мэдэгдэл бичиж 8 мэдэгдлийн хариуг хугацаанд нь авч, мэдэгдлийн мөрөөр 6 удаагийн нэгдсэн үзлэг шалгалтыг явуулсан.

Аймгийн баяр наадмын өдрүүдэд аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөр 1 сая төгрөгийн 1000 ширхэг тараах материал зурагт хуудас, санамж сэрэмжлүүлэг, хулдаасан хэвлэл шийдвэрлүүлж олон нийтийн газар, үйлчилгээний цэгүүдэд байршуулсан. Мөн “Үер усны аюул” хэсэгчилсэн арга хэмжээг Онцгой байдлын газар, Мөрөн сумтай хамтран зохион байгуулж Дэлгэрмөрөн голын эрэг орчмоор завьт болон морьт эргүүлийг ажиллуулж амарч байгаа иргэдэд аюулгүй байдлаа хангах чиглэлээр 825 хүнд зөвлөгөө, санамж сэрэмжлүүлэг өгч ажилласан. Арга хэмжээний хүрээнд зарцуулах 518 мянган төгрөгийн шатах тослох материалыг шийдвэрлүүлээ.

“Устгал” арга хэмжээний хүрээнд 500 мянган төгрөг шийдвэрлүүлж Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч нар устгалыг хийж ажилласан байна. Мөн хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 сумын баяр наадмын үеэр 860 хүүхдэд төөрч алга болохоос урьдчилан сэргийлж гарын бугуйвч зүүж өгч ажилласан байна.

Гурав. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2023 оны 07-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас **21.8** тэрбум төгрөгний **1285** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2023 оны 07 дугаар сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 26,427.8 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 28,454.9 сая төгрөг буюу 107.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2023 оны 07 дугаар сарын мэдээгээр Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан 44,294.8 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 2,886.5 сая төгрөг нь татварын бус орлого буюу өөрийн орлогоос, 38,531.5 сая төгрөг нь төсвөөс санхүүжих, 13,6177 сая төгрөг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс, 6.922.7 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 44,294.8 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 30,741.2 мянган төгрөг буюу 69.4 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,144.2** сая төгрөг өмнөх сараас **69.8** сая төгрөгөөр буурсан.

Нийт өглөг **934.4** сая төгрөг өмнөх сараас **267.2** сая төгрөгөөр буурсан.

2023 оны 07 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 4021.6 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 307.6 сая төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 98.9 хувьтай байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	3177	3483.1	109.6
Тэтгэмж	321.5	380.3	118.3
ҮОМШӨ	240.6	304.1	126.4
ЭМД	0,0	0,0	0,0
Ажилгүйдэл	60.0	73.0	121.7
Дүн	3799.1	4240.5	119.0

Тэтгэврийн даатгалын сангаас 21761 тэтгэвэр авагчид 11046.5 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 3 төрлийн тэтгэмж 355 даатгуулагчдад 348.3 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, үйлдвэрлэлийн ослын сангаас 67 даатгуулагчдад 33.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 93 даатгуулагчид 69.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 116.9 сая төгрөг байна.

Аймгийн Санхүү хяналт дотоод аудитын алба 2023 оны 07 дугаар сард аймгийн Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний зардлын үр дүн, гүйцэтгэлд, Түрээсийн орон сууцны эргэлтийн сан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.

2023 оны 07 дугаар сарын байдлаар 275 албан бичиг хүлээн авч, хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 103 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Оны эхнээс 23 өргөдөл, хүсэлт хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн 22, хянагдаж байгаа 1 өргөдөл байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эрүүл мэндийн газраас аймгийн Нэгдсэн эмнэлэг болон харьяа Эрүүл мэндийн байгууллагуудаас ажлын байрны сул орон тооны судалгааг авч нэгтгэн байгууллагын албан ёсны пэйж хаяг болон цахим хуудсанд байршуулан ажиллалаа. 2023 оны 7 сарын байдлаар Нэгдсэн эмнэлэг болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 52 эмнэлгийн мэргэжилтний орон тоо байгаа ба тус байгууллагуудад орох хүсэлт гаргасан эмнэлгийн мэргэжилтэй иргэдийг бүртгэн авч байна.

Эрүүл мэндийн Сайдын 2023 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 04 дүгээр албан даалгаврын хүрээнд ахуйн болон зам тээврийн осол гэмтэл, хоолны хордлого, үер усны аюул, бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах, тарваган тахал, боом, хачигт халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагуудаас хүргэж буй зөвлөгөө мэдээллийг хүлээн авч хүний амь нас эрүүл мэндэд учирч болохуйц эрсдэлт хүчин зүйл үүссэн тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагуудын лавлах утсанд цаг алдалгүй түргэн шуурхай хандах болон амралтын

өдрүүдээр ажиллах хувийн хэвшлийн эмнэлгүүдийн цагийн хуваарь, байршил, Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай түргэн тусламжийн дуудлагын утасны дугаарыг олон нийтэд хүргэж ажиллаа.

Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор "СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ХҮН БҮРД" аян орон даяар зохион байгуулагдаж байна.

ЗООНОЗ-ын өвчин судлалын төвийн 2023 оны календарьчилсан төлөвлөгөөний дагуу 2023 оны 7-р сарын 19-20-ны өдрүүдэд ЗӨСТ -ийн дарга Б.Уртнасан, биологич Ү.Уяа-Эрдэнэ, шимэгч судлалын лаборант Ж.Саранцэцэг, амьтан судлалын лаборант Э.Ундрахбаяр, жолооч Д.Ням-Очир нар тус аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны эрүүл мэндийн төвийн халдварт өвчнөөс сэргийлэх сэжигтэй дуудлагын бэлэн байдалд хяналт хийх үнэлэх," Эрхэл" нууранд ус намгийн шувууд тоолох ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тооллогод 11 зүйлийн 834 шувуу тоологдсон ба үүнээс 385 нь бие гүйцсэн, 449 нь залуу шувуу байсан. Мөн шувуудын төрх байдал зан төлөвт ажиглалт хийхэд ямар нэг өөрчлөлтгүй, үхсэн шувуу, шувууны сэг зэмгүй тайван байгааг илтгэлээ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ehalamj.mn-ээр 80363 иргэнд 8.5 тэрбум төгрөгийг олгосон. 2023 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комисс 7 дугаар сард 1 удаа хуралдаж 11 хүүхдийн өргөдлийг хэлэлцэн байнгын асаргаанд 5, асаргааны сунгалт хийлгэсэн 1, хуулийн заалтад нийцээгүй 2 хүүхдийн өргөдлийг буцаан шийдвэрлэсэн байна. Ахмадын Эрчим-1, Эрчим-2 амралтад 7 дугаар сард нийт 310 ахмад хүлээн авч амруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 236 дугаар тогтоолоор 2023 оны 1 дүгээр сараас хойш 6 сар хүүхдийн мөнгөнд хамрагдаагүй байсан 11497 хүүхдийн мөнгийг нөхөн олгосон. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд 7 бүлэгт 15 сая төгрөгийг олгосон.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний EJOB платформд 2023 оны 7 дугаар сарын 31-ний байдлаар 98 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 8 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан байна. Ажил хайгч болон зорилтот бүлгийн 31 иргэнийг оёдол эсгүүрийн мэргэшүүлэх түр сургалтад 21 хоногийн хугацаанд хамруулж чадавхжууллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт 96 иргэнийг хамруулж 726 сая, малжуулах арга хэмжээнд 52 өрхийг хамруулж 260 сая, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 25 ахмад хамруулж 100 сая, түрээсийн хөнгөлөлтөд 1 иргэн хамруулж 1,2 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 28 иргэнийг хамруулж 173 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 3-5 жилийн хугацаатай олгоод байна. Нийтийг хамарсан ажилд 149 хүн хамрагдаж 51,8 сая, мод тарих ажилд 148 хүн хамрагдаж 61,6 сая төгрөгийн цалин, хөлсийг тус тус олголоо.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөвсгөл аймгийн Их-Уул суманд 8 буган хөшөөг шинээр илрүүлсэн бөгөөд, хүзүүний зүүлт нь дөрвөлжин хээтэй ийм зүүлт бүхий буган хөшөө Монгол Улсад 2-3 ширхэг байдаг аж.

Монголын “Саран ээж” нийгэмлэг, Чандмань-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газартай хамтран Ариг голын хөвөөнд “Алунгоо эхийн сургаалын баяр-5 “ эвент арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээ нь эв эеийг эрхэмлэх наадам бөгөөд Ариг голын хөвөөнд төрсөн Алунгоо эхийн сургаалийг алдаршуулахад оршино.

“САРЛАГ НААДАМ”-2023 арга хэмжээ Алаг-Эрдэнэ сумын Далан булгийн талд 2 өдөр үргэлжилж амжилттай өндөрлөлөө.Энэхүү наадам нь сарлаг үхрийн ашиг шимийг нэмэгдүүлэх, малчин иргэдийг дэмжих, уламжлалт өв соёл, мал маллах арга ухааныг сурталчилан таниулах, сарлагийн бүтээгдэхүүнийг зах зээлийн эргэлтэд оруулах, аялал жуулчлалын эвэнт арга хэмжээ болгох зэрэг ач холбогдолтой юм.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Аймгийн Соёл урлагийн газартай хамтран Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Тариат, Бүгдгээн чиглэлийн үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хөвсгөл марофон гүйлтийн тэмцээнд 8 наснаас 80 настай тамирчид, өндөр зэрэглэлийн тамирчид спортын мастерууд насны ангиллаараа хамрагдаж олноороо оролцсон өндөр зэрэглэлийн чансаа өндөр тэмцээн болж 8 насны ангиллаар 500 гаруй тамирчид оролцлоо

Биеийн тамир спортын газраас “Цаг гаргая” аяны хаалтыг зохион байгуулж гир өргөх, гэдэс таталт, гар дээр сунайлтын гурван төрлийг зохион байгуулж нийт 30 гаруй хүн хамрагдлаа шангалыг тус бүрийн эхний 5-н байраар тасалж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Бадминтоны нээлттэй тэмцээнд 18 байгууллагын 110 гаруй тамирчид 3 насны ангилалд 5 төрлөөр өрсөлдөж шилдэгүүдээ шалгаруулсан юм.

Спортын дэд мастер Ё.Батдэлгэр агсны нэрэмжит "Хөвсгөл цом 2023" Олон хотын ширээний теннисний тэмцээн өсвөр үе, насанд хүрэгчид, ахмад насны ангилалаар зохион байгуулагдаж ОХУ, ӨМӨЗО, болон Төв, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Эрдэнэт, Дархан- Уул аймгийн 250 гаруй тамирчин оролцлоо.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ГБЗХГ-ын дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2023 оны 7 дугаар сард нийт 51 иргэн үйлчлүүлсэн байна. Үүнээс өдрөөр насанд хүрэгч 23 иргэн хамрагдснаас 11 эмэгтэй, 12 эрэгтэй, 28 хүүхдийн 14 эрэгтэй, 14 эмэгтэй, мөн 24 иргэн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлсэн.

Сургалт, нөлөөллийн ажилд 1238 хүүхэд, 246 насанд хүрэгч, 16 гэр бүл, 38 залуучууд хамрагдсан байна.

Байгууллагын фейсбүүк хуудсаар дамжуулан 5 зөвлөмж, 9 мэдээ, 1 ажлын байрны зар, 2 танилцуулгыг иргэд олон нийтэд хүргэж 17335 хандалт авсан байна.

Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг зуслан хөгжлийн хөтөлбөрт тэгш хамруулах зорилгоор Дархан-Уул аймгийн Зулзагын гол зусланд “Майхант цугларалт-2023”-арга хэмжээг зохион байгуулж 82 хүүхэд оролцон, “Сайн байна уу зуслан минь”, “Хамтдаа бүтээцгээе”, “Хүүхдийн зөвлөлийн өдөр”, “Монгол бахархал”, “Баяртай зуслан минь” 5 өдрийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд зохион байгуулалт сайтайгаар оролцлоо.

Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, иргэдийг арга зүйгээр хангах зорилгоор “Ураг удам-2” аяныг 2 дахь жилдээ зохион байгуулж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Үндэсний хурдан морины уралдааны явцад хүүхдийг ослын даатгалд даатгуулсан эсэх болон стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавих тухай заалтын хэрэгжилтийг хангав. Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандартыг сурталчлан таниулсан. Хөвсгөл аймгийн хэмжээнд нийт 3979 морь уралдаж, 958 унаач хүүхэд оролцсоноос 20 хүүхэд мориноос унаж хөнгөн зэргийн бэртэл гэмтэл авсан байна. Бэртэл гэмтэл авсан уралдаанч хүүхдүүдийг цаг алдалгүй эрүүл мэндийн үзлэгт оруулж, эцэг, эх асран хамгаалагчдад хүлээлгэн өгч ажилласан.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгмийн болон хувийн амьдралдаа адил тэнцүү үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, тэгш хариуцлага, тэгш оролцоотой болох чиглэлээр газрын мэргэжилтнүүд чадавхижж, энэ сард 16 залуу төрийн албан хаагчдад дээрх мэдээллийг өгч ажиллалаа.

Мөрөн сумын 14 багийн Засаг дарга, тэдгээрийн 15 өрхөөр айлчлагч нарыг хамруулсан “Өглөөний уулзалт”-ыг ДЗМОУБ-ын “Хөвсгөл” ОНХ-ийн мэргэжилтэн Э.Эрдэнэсүрэнтэй хамтран зохион байгуулав.

Уулзалтаар өрхөөр айлчлагч нарын өмнө тулгамдаж буй асуудлыг сонсож, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар саналыг цаасаар авч ажиллалаа. Өрхөөр айлчлагч нарын өмнө нийтлэг тулгамдаж буй асуудал нь цалин, урамшууллын асуудал байгааг ярьж байв. Сум, орон нутгийн удирдлагуудад танилцуулж, шийдвэрлэж ажиллахаа багийн дарга нар хэлж байв. Цаашид өглөөний уулзалтыг сар бүр тогтмол зохион байгуулахаар ярилцав.

НҮБ-ын Хүн амын сан, Юнител групптэй хамтран E-HUB төслийг амжилттай хэрэгжүүлж, 45 сая төгрөгийн санхүүжилттэй HUB танхимыг Хүүхдийн ордонд байгууллаа. Уг төсөл нь ухаалаг таблет, электрон тоног төхөөрөмж, өндөр хурдны интернетээр хангагдсан орчин үеийн шинэлэг орчинг бүрдүүлсэн. Залуучуудын цахим хэрэглээ, боловсролыг дээшлүүлэх, хөгжлийг дэмжих, орон нутгийн өсвөр үеийнхэн, иргэд, залуучуудад зориулсан цахим үйлчилгээ үзүүлэх танхим юм.

Тав. Мал аж ахуй, газар тариалангийн талаар:

Аймаг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Түнэл, Бүрэнтогтох сумдад малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн мөшгөх системийг нэвтрүүлэх ажлын Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо хариуцан гүйцэтгэж эхний ээлжийн сургалт мэдээллүүдийг хөрөнгө оруулалт тусгагдсан сумдын малчдад хүргэж ажиллаж байна.

Эдгээр сумдад малын гаралтай түүхий эдийн мөшгөх систем буюу Хариуцлагатай нүүдэлчин стандартыг нэвтрүүлснээр гарал үүсэл нь тодорхой эргэн мөшгөх боломжтой малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний малчид нэгдэн нийлж хоршоогоор дамжуулан дотоод гадаадын зах зээлд нэмүү өртөг шингээн худалдан борлуулах боломж бололцоо нээгдэж байгаа юм.

“Хөвсгөлд Зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалын эвент арга хэмжээ болгон “Сарлагийн наадам-2023” энэ оны долоодугаар сарын 20-21-нд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын 5 дугаар багийн нутаг Далан булагт зохион байгууллаа. Хөвсгөл аймгийн 22 сум, нэг тосгонд нийт 170 мянга гаруй толгой сарлаг маллаж байна.

Наадмыг зохион байгуулагч Алаг-Эрдэнэ суманд гэхэд л нийт үхрийн 90 хувь нь сарлаг юм. Хөвсгөл аймагт үйл ажиллагаагаа явуулж буй “Жинст мөрөн” компани сарлагийн хөөврөн бүтээгдэхүүнээ Европын орнуудад сурталчлах ажлыг хийж байгаагаас гадна Герман улсад сарлагийн хөөврөн бүтээгдэхүүний дэлгүүр нээсэн.

Мөн малчид маань ч гэсэн сүүлийн үед сарлагийн хөөврийг маш сайн самнаж өгч байгаа бөгөөд 2017 онд нэг тонн хөөвөр авч байсан бол 2023 онд 3 тонн хөөврийг зөвхөн Алаг-Эрдэнэ сумын малчид нийлүүлдэг болсон нь Хөвсгөл аймагт Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломж байгаа нь харагдаж байгаа юм.

Монгол улсад шинжлэх ухааны үндэслэлтэй Мал аж ахуйн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Хоймор нутгийн Малзүйчдээ алдаршуулая цуврал танилцуулга мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан. Мөн 100 жилийн түүхэн ном гаргах ажлын гүйцэтгэн ажиллаж байна.

Мал үржлийн албаны мэргэжилтнүүд Хөвсгөл аймгийн баяр наадам, Баянзүрх сумын 90 жил, Рашаант сумын 100 жил зэрэг арга хэмжээнд хурдан морины сэрвээ хэмжих хариуцлагатай албан үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Хөвсгөл Цагаан-Уул сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Уул уурхайн лицензийн талбайн ургамлын хэв шинж, ховор, ховордсон ургамал, бэлчээрийн хортой ургамлын судалгаа” хийлгэхээр хуулийн дагуу тендерийг зарлан “Хөвсгөл далай ээж” ТББ гүйцэтгэгчээр шалгарсан. Гүйцэтгэгч компанийн хээрийн судалгааны ажлыг Доктор Ж.Оюумаа, доктор Л.Жаргалсайхан нар хариуцан ахлаж 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 2023 оны 07 дугаарын 06-ны өдөр дуустал судалгааны ажлын бүрэлдэхүүн хэсэгт оролцож хамтран ажилласан.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯРМАА